

ХОВД АЙМАГ ДӨРГӨН СУМ

# **МАЛЖУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР**

2014 ОН

## **ДӨРГӨН СУМЫН МАЛЖУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР**

### **Нэг: Нийтлэг үндэслэл**

1. Сумын үндсэн салбар нь мал аж ахуй бөгөөд орон нутгийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтэнд онцгой байр суурь эзэлдэг уламжлалт салбар мөн. Сумын дүнгээр 130 –аас доош толгой малтай малчин өрх 2011 оны жилийн эцсээр 130, 2012 оны жилийн эцсээр бүгд 81 байна. Энэ нь малчдын амьжиргааны талаархи сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд малчин өрхийн малын тоо 130 толгойгоос доош байхад мал аж ахуйгаас олох нийт мөнгөн орлого нь малчин өрхийн нийт хэрэглээ ба зардлыг нөхөж чадахгүй байна.

Харин 200-300 толгой малтай байхад байнгын хөдөө мал малладаг малчин өрхийн орлого нь зардлаа нөхөж боломж байгааг тооцсон байдаг. Иймд сумын малчин өрхүүдийн малын тооны доод хязгаарыг 200 толгой малтай болгох зорилго нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

### **Хоёр: Хөтөлбөрийн зорилго**

Сүүлийн жилүүдэд дараалан болсон ган, зуд болон нийгмийн бусад олон хүчин зүйлүүдээс шалтгаалж мал нь цөөрсөн байнгын хөдөө байдаг малчин өрхүүдийг “Малжуулах” тэдний амьдралыг дээшлүүлж зах зээлд өрсөлдөх чадвартай болгоход энэхүү хөтөлбөрийн гол зорилго оршино.

### **Гурав: Хөтөлбөрийн зорилт**

3. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна.

3.1.Хөтөлбөрийн зорилго ач холбогдлыг олон нийтэд сурталчлан ойлгуулах.

3.2.Хөтөлбөрт хамрагдсан малчин чанартай мал авч малынхаа тоо толгойг нэмэгдүүлэх.

3.3. Хөтөлбөрт 50-130 малтай өрхийг хамруулах.

3.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.

### **Дөрөв: Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа**

4.1.Хөтөлбөрийн 3.1 дэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

а/ Баг бүрийн иргэдийн нийтийн хурлаар хөтөлбөрийн зорилго, ач холбогдлыг малчин ард иргэдэд сурталчлан таниулна.

б/ Малжуулах хөтөлбөрт хамрагдах малчдыг сонгон шалгаруулах журам боловсруулж, батлуулах

в/ Малжуулах хөтөлбөрт хамрагдах 50-130 малтай өрхийн нэрсийг багийн иргэдийн нийтийн хурлаас санал гаргуулах

4.2. Хөтөлбөрийн 3.2. дахь зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

а/ Хөтөлбөрт хамрагдсан малчин нь Өлгийн улаан, Дөрвөлжингийн халтар ямаа, Сутай, Баяд омгийн хонь болон нутгийн ашиг өндөртэй мал авах чиглэл баримтлан сүргийн бүтцийн зохистой харьцаа, чанартай сүрэг бий болгох

б/ Хөтөлбөрт хамрагдсан малчдын малыг мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тогтмол хамруулах.

4.3. Хөтөлбөрийн 3.3. дахь зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

а/ Хөтөлбөрт хамрагдах малчинтай нэг бүрчлэн гэрээ байгуулж ажиллана.

б/ Тухайн малчин хоёр жилийн хугацаанд хөтөлбөрт хамрагдана.

в/ Хөтөлбөрт хамрагдаж байгаа малчдад хугацаанаас нь хамаарахгүйгээр адил тооны малаар малжуулна.

4.4. Хөтөлбөрийн 3.4. дэхь зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

✓ 2013 онд 12 малчин 60 сая төгрөг

✓ 2014 онд 12 малчин 60 сая төгрөг

✓ 2015 онд 24 малчин 120 сая төгрөг

✓ 2016 онд 24 малчин 120 сая нийт давхардсан тоогоор 360.000.000 төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг бий болгож 72 малчинг хамруулна.

### **Тав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

#### **5.1. 2013-2016 он.**

#### **Зургаа: Хөтөлбөрийн үр дүн**

Хөдөө байнга мал маллаж байгаа 50 -130 толгой малтай 72 малчин өрхийг төсөл хөтөлбөрт хамруулж малын тооны доод хязгаарыг 200-д хүргэнэ.

Малын тоо толгой өсөж, чанар сайжирснаар малчдын өрхийн орлого нэмэгдэж зах зээлд өрсөлдөх чадвартай болно.

-----oOo-----